



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мандалговь хот

2022 он

Дарга,гэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	мянган төгрөгөөр4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	мянган төгрөгөөр.....4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	мянган төгрөгөөр.....5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	мянган төгрөгөөр5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	мянган төгрөгөөр6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	мянган төгрөгөөр.....8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 № 92

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020920

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		858,806.3	1,548,450.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	214,261.8	507,035.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	315,896.3	423,777.6
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	215,648.2	484,637.4
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	-	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	113,000.0	133,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,502,575.9	9,229,180.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,502,575.9	9,229,180.1
39100	Газар		-	-
39200	Биет хөрөнгө		6,326,650.4	9,034,106.6
39300	Биет бус хөрөнгө	13	175,925.5	195,073.5
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,361,382.2	10,777,630.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		17,054.2	24,846.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	17,054.2	24,846.0
41300	Өглөг	17а, 17б	17,054.2	24,846.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,344,328.0	10,752,784.3
51	Засгийн газрын хувь оролцоо		7,344,328.0	10,752,784.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		3,171,044.5	3,558,076.4
51200	Хуримтлагдсан үр дүн		2,089,458.9	4,900,995.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,083,824.6	2,293,712.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,361,382.2	10,777,630.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,038,021.0	6,579,396.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		118,660.8	220,206.5
110	Орлогын албан татвар		56,863.5	40,154.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		56,863.5	40,154.6
113	Хөрөнгийн албан татвар		1,155.0	100,607.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		60,642.3	79,444.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	880,780.4	1,630,045.9
120	Нийтлэг татварын бус орлого		880,780.4	1,630,045.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,038,579.8	4,729,144.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,382,545.4	5,787,097.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,382,545.4	5,787,097.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,287,341.5	5,612,082.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,908,792.7	2,529,668.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		239,628.5	325,108.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		298,602.4	419,117.2
2104	Хангамж, бараа материалын зардал		94,259.0	344,513.2

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал		87,302.5	519,369.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		40,014.0	58,566.2
2107	Томилолт, зочны зардал		9,050.3	6,588.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		56,946.2	67,488.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		552,745.9	1,341,663.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,095,203.9	175,015.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		655,475.6	792,298.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		233,190.5	161,383.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		422,285.2	630,914.9

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,649,351.7	-	6,649,351.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	272,691.1	-	272,691.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,922,042.8	-	6,922,042.8
9	Тайлант үеийн үр дүн	422,285.2	-	422,285.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,344,328.0	-	7,344,328.0
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,344,328.0	-	7,344,328.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,777,541.4	-	2,777,541.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,121,869.4	-	10,121,869.4
19	Тайлант үеийн үр дүн	630,914.9	-	630,914.9
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,752,784.3	-	10,752,784.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,367,834.4	5,041,011.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	118,660.8	220,206.5
110	Орлогын албан татвар	56,863.5	40,154.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	56,863.5	40,154.6
113	Хөрөнгийн албан татвар	1,155.0	100,607.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	60,642.3	79,444.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,495.6	10,408.5
1181	Газрын төлбөр	9,346.7	14,431.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	44,800.0	54,604.8
1183	Бусад татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,593.7	255,417.8
120	Нийтлэг татварын бус орлого	210,593.7	255,417.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,038,579.8	4,565,387.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,965,253.1	4,525,938.6

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,965,253.1	4,525,938.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,869,509.1	4,349,235.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,908,574.6	2,529,668.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,645.8	325,108.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,626.4	436,122.4
2104	Хангамж, бараа материалын зардал	92,665.6	162,754.3
2105	Нормативт зардал	83,448.4	487,316.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,664.4	110,068.8
2107	Томилолт, зочны зардал	9,050.3	6,588.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,711.6	68,520.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,122.0	223,087.1
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,095,744.0	176,703.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	402,581.2	515,072.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	262,037.2	222,299.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	262,037.2	222,299.5
2200	Дотоод эх үүсвэрээр	262,037.2	222,299.5
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(262,037.2)	(222,299.5)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(150,000.0)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(9,455.9)	292,773.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	223,717.8	214,261.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	214,261.8	507,035.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,733,311.4	4,220,820.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,193,620.7	4,066,846.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,085,525.6	3,959,040.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,526,029.8	2,498,042.7
210101	Үндсэн цалин	1,656,735.1	1,651,316.1
210102	Нэмэгдэл	661,593.5	646,275.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,430.0	7,240.0
210104	Урамшуулал	200,271.2	193,210.8
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,554.3	323,158.4
210201	Тэтгэврийн даатгал	230,863.6	228,310.2
210202	Тэтгэмжийн даатгал	24,794.2	24,360.9
210203	ҮОМШО-ний даатгал	19,766.6	19,630.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,796.3	4,683.1
210205	Эрүүл мэндийн даатгал	47,333.6	46,173.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	402,242.6	402,131.6
210301	Гэрэл, цахилгаан	36,910.9	34,908.2
210302	Түлш, халаалт	362,200.7	364,095.6
210303	Цэвэр, бохир ус	3,131.0	3,127.8
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	142,965.2	142,718.5

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	11,836.2	11,687.0
210402	Тээвэр, шатахуун	72,663.2	72,648.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,028.1	9,988.1
210404	Ном, хэвлэл	1,454.2	1,441.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,315.6	4,362.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,667.9	42,591.0
2105	Нормативт зардал	286,728.3	264,249.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	129,083.3	106,767.9
210502	Хоол, хүнс	132,766.9	132,764.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,878.1	24,717.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	140,280.3	140,208.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,997.6	56,997.0
210602	Тавилга	24,009.4	24,009.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	59,273.3	59,202.2
2107	Томилолт, зочны зардал	7,888.2	6,532.1
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	7,888.2	6,532.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,372.8	27,544.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,757.0	22,114.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	674.6	592.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	927.9	888.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	331.0	330.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,816.0	1,753.5
210807	Газрын төлбөр	866.3	866.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000.0	999.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	223,464.1	154,455.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	215,610.6	146,620.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,853.5	7,835.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,095.1	107,806.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,095.1	107,806.1
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	12,597.7	12,597.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	76,930.5	76,653.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,586.9	7,586.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,980.0	10,968.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	331,190.7	153,974.0
223001	Бусад хөрөнгө	331,190.7	153,974.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	208,500.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	208,500.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,733,311.4	4,522,193.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,150,856.7	3,147,711.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,951,553.1	2,948,407.7
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	199,303.6	199,303.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,164,308.5	1,161,593.3
320001	Орон нутгийн төсвөөс	1,164,308.5	1,161,593.3
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,059.1	32,526.2
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	69,059.1	32,526.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	349,087.1	180,362.8

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	132,500.0	100,837.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,000.0	79,525.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	140,587.1	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	113,748.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	420,973.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		560,488.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		560,488.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		494,736.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		31,626.3
210102	Нэмэгдэл		15,541.2
210104	Урамшуулал		16,085.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,949.6
210201	Тэтгэврийн даатгал		1,354.7
210202	Тэтгэмжийн даатгал		158.8
210203	ҮОМШӨ-ний даатгал		127.1
210204	Ажилгүйдлийн даатгал		27.3
210205	Эрүүл мэндийн даатгал		281.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		33,990.8
210301	Гэрэл, цахилгаан		467.8
210302	Түлш, халаалт		3,900.0
210303	Цэвэр, бохир ус		29,623.0
2104	Хангамж, бараа материалын зардал		29,834.0
210401	Бичиг хэрэг		2,722.1
210402	Тээвэр, шатахуун		21,187.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		901.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,022.6
2105	Нормативт зардал		223,067.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		192,655.2
210502	Хоол, хүнс		30,412.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		27,188.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		23,690.0
210604	Урсгал засвар		3,498.0
2107	Томилолт, зочны зардал		56.0
210702	Дотоод албан томилолт		56.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		40,976.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		40,976.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		106,048.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		105,053.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		995.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		65,752.1
2132	Бусад урсгал шилжүүлэг		56,492.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		53,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,292.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		9,259.2
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		9,259.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		577,812.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		577,812.3
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		11,327.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		204,824.4

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		59,829.1
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		301,831.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		17,323.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		17,323.6

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 29 дүгээр тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Эрдэнэдалай сум нь эрхэм зорилгоо “Төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулж, өрхийн амьжиргааны чадавхыг дээшлүүлэх, хүний хөгжлийг бүх талаар хангах замаар орон нутгийн тогтвортой хөгжлийг хангана” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд 2021 онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй, өгөгдсөн зөвлөмж байхгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,787,097.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 57,871.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 40,509.7 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,416,248.1 мянган төгрөгөөр буюу 46.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	214,261.8	507,035.2	292,773.4
Авлага	315,896.3	423,777.6	107,881.3
Бусад эргэлтийн хөрөнгө	215,648.2	484,637.5	268,989.3
Бараа материал	113,000.0	133,000.0	20,000.0
Үндсэн хөрөнгө	6,502,575.9	9,229,180.1	2,726,604.2
Нийт хөрөнгө	7,361,382.2	10,777,630.3	3,416,248.2
Өр төлбөр	17,054.2	24,846.0	7,791.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,344,327.9	10,752,784.3	3,408,456.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,361,382.2	10,777,630.3	3,416,248.2

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 292,773.4 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлыг 331,190.7 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч цар тахлын улмаас хил хаагдаж бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим үйл ажиллагааг хязгаарлаж байснаас цаг хугацааны хувьд хойшлогдсон зэргээс шалтгаалан 153,974.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь нөлөөлсөн.

Мөн Сум дундын эмнэлгийн харилцах дансны 34,476.7 мянган төгрөгийн үлдэгдэл төвлөрүүлэгүйтэй холбоотой байна

Авлагын дансны үлдэгдэл 107,881.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 211,073.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 20,000.0 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах хамгаалах хэрэгслийг Эрүүл мэндийн төвд хүлээн авч бүртгэж тайлагнасангай холбоотой.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 68,325.5 мянган төгрөг, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй хүлээн авсан болон шилжүүлэн авсан 3,242,436.5 мянган төгрөг, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан 261,652.7 мянган төгрөг, нийт 3,572,414.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 391,175.9 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,752,784.3 мянган төгрөг болж 3,408,456.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Эрдэнэдалай сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 38 дугаар тогтоолоор Эрдэнэдалай сум тайлант онд 223,400.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 289,409.70 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 129.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Үйл ажиллагааны орлого	28,000.0	33,812.6	5,812.6	120.8
Хөрөнгө борлуулсны орлого	-	6,342.0	6,342.0	
Бууны албан татвар	1,600.0	1,230.0	(370.0)	76.9
Улсын тэмдэгтийн хураамж	2,500.0	3,831.5	1,331.5	153.3
Малын тоо толгойн албан татвар	100,000.0	99,377.1	(622.9)	99.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		54,604.8	54,604.8	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,000.0	567.7	(1,432.3)	28.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,000.0	6,009.3	1,009.3	120.2
Газрын төлбөр	14,000.0	14,431.6	431.6	103.1
Дүн	153,100.0	220,206.6	67,106.6	
Татварын бус орлого				
Хүүгийн орлого	60,300.0	61,596.1	1,296.1	102.1
Торгуулийн орлого	9,000.0	7,607.0	(1,393.0)	84.5
Бусад орлого	1,000.0	-	(1,000.0)	-
Дүн	70,300.0	69,203.1	(1,096.9)	
Нийт дүн	223,400.0	289,409.7	66,009.7	129.5

Хувь хүний орлогын албан татварын орлого 5,812.6 мянган төгрөгөөр давсан нь “Эрдэнэс Таван толгой” ХК иргэдэд хувьцааны ногдол ашиг олгож, ногдол ашгаас суутгасан татварыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1,432.4 мянган төгрөгөөр тасарсан нь тус суманд ковид -19 цар тахалтай холбоотой блок хийдэг аж, ахуй нэгжүүд ажиллаагүйтэй холбоотой.

Торгуулийн орлого 1,393.0 мянган төгрөгөөр тасарсан нь ковид-19 цар тахлын улмаас иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж хөл хорио тогтоож зөрчил бага гарсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрдэнэдалай сумын ИТХ-ын 2020 оны 38 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,492,949.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,492,949.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Эрдэнэдалай сумын ИТХ-ын 2020 оны 25 болон 32 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 240,362.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 4,733,311.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 40 арга хэмжээг санхүүжүүлэхээр урсгал зардалд 4,193,620.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 331,190.7 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлд 208,500.0 мянган төгрөг, нийт зардлыг 4,733,311.4 мянган төгрөгөөр төлөвлөж баталжээ.

Нийт зардлын 3,150,856.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,164,308.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 69,059.1 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 349,087.1 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 3,147,711.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,161,593.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32,526.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 180,362.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос тус тус төвлөрүүлж нийт 4,522,193.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн.

Үүнээс 4,066,846.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 153,974.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд нийт 4,220,820.5 мянган төгрөг буюу 89.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Нийт зардлын 59.9 буюу ихэнх хувийг ажиллагсадтай холбоотой зардал эзэлж байна.

Санхүүжилтээс дутуу зарцуулсан 3,145.4 мянган төгрөгийг улсын төсөвт, 1,454.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 204,824.4 мянган төгрөг, хандиваар 11,327.3 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны орлогоос 59,829.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлогоос 301,831.5 мянган төгрөг, нийт 577,812.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 31,626.26, НДШ-ийн зардалд 1,949.64 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 33,990.7 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 29,834.0 мянган төгрөг, нормативт зардалд 223,067.4 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 27,188.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 40,976.2 мянган төгрөг, томилолтын зардалд 56.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 106,048.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 65,752.1 мянган төгрөг, нийт 560,488.7 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 9,259.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд 17,323.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд малчдад туслах 23,516.5 мянган төгрөгийн хандив орж ирснээс малын эрлийн шатахуун, сэг зэм устгах ажлын хөлсөнд 20,168.7 мянган төгрөгийг зарцуулсан. Цар тахалтай холбоотой 54,300.9 мянган төгрөгийн хандив орж ирснээр халдвар хамгааллын хувцас,

түргэвчилсэн оношлуур авах, сумын онцгой комиссын хяналтын постын шатахуун, хүнс, хамгаалах хэрэгсэл зэрэгт зарцуулжээ.

Сум дундын эмнэлэгт Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 564,411.3 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин хүлээн авч, 474,016.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хуваарилсан ковид-19-н 48 ширхэг вакциныг илүү орлогод тусгасан 1,777.8 мянган төгрөгийн, эм нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү дүнгээр нэхэмжилсэн 200 ширхэг эмийн үнэ 2,570.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

3.8 Аудитын гол асуудал

Эрдэнэдалай сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хэвийн бус ажил гүйлгээ гараагүй.

Харин удирдлага зохион байгуулалтын хувьд доголдолтой, дотоод хяналт хангалтгүй аудитор өндөр шүүмжлэлтэй хандаж буй эрсдэлтэй асуудал нь аймгийн Эрүүл мэндийн газраас нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн орлогыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зарцуулалтад хяналт тавиагүй асуудал байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг дарга нь 2021 онд нийт 155 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”, төсөвт тодотгол хийж иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Гамшгийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ” болон “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр” -ийн урсгал зардлыг санхүүжүүлсэн зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 12,747.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	8	20,376.9	5	13,792.0	3	6,584.9	67.6
Албан шаардлага	8	68,838.6	8	68,838.6			100
Зөвлөмж							
Нийт	16	89,215.5	13	82,630.6	3	6,548.9	83.8

Өмнөх оны Сум хөгжүүлэх сангийн төлбөрийн акт нь хугацаа хэтрэлттэй зээл болон зориулалт бус зээлд төлбөрийн акт тавьсан байна. Үүнээс зарим нэг хугацаа хэтрэлттэй зээл нь цар тахлын улмаас үйл ажиллагаа явуулж чадаагүйгээс зээлээ төлж чадаагүй, мөн зориулалт бус зээлийн үлдэгдэл төлөгдөөгүй үлдсэн байна.

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Сум дундын эмнэлгийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газар, Сум дундын эмнэлэг, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 143,989.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 67,889.1 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 74,389.8 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага, 1,711.0 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлжээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 52.9 хувийг залруулагдаагүй, 47.1 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 70,656.1 мянга буюу 48.7 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 74,389.8 мянган төгрөг буюу 51.3 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Байгаль хамгаалах сангийн 1,056.0 мянган төгрөгийн бараа материалын орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/ заасныг тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Дээрх 1,056.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулсан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ОНХС	1	70,000.0					1	70,000.0		
2	ЕБС	1						1			
	дүн	2	70,000.0					2	70,000.0		
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЗДТГ	1	3,536.4					1	3,536.4		
2	ЭМТ	4	29,338.4	4	29,388.4						
3	ИТХ	2	853.4					2	853.4		
4	ЦЭЦЭРЛЭГ	2	40,211.7	1	38,500.7					1	1,711.0
5	БХС	1	1,056.0	1	1,056.0						
	дүн	10	75,045.9	6	68,945.1			3	4,389.8	1	1,711.0
	Нийт зөрчлийн дүн	12	145,045.9	6	68,945.1	-	-	5	74,389.8	1	1,711.0